

ДИПЛОМАТ ХАРИЛЦААНЫ ХЭЛ: ОРЧУУЛГА БА ХЭЛМЭРЧЛЭХҮЙ

Б. Батчимэг⁵⁶

Ш. Болормаа⁵⁷

Abstract: *Diplomatic translation represents one of the most complicated, advanced, and toughest translation activities in the modern world. Diplomatic translation is carried out within diplomatic missions, embassies and consulates. This paper aims to explore the language of diplomacy which has been used since the ancient times until today and how the usage decreased and increased over the period of the time; the functions and features of diplomatic interpretation and translation. In addition to that, the paper highlighted some challenges encountered by interpreters and translators; also emphasized newly-emerged terms and discourses in the language of diplomacy.*

Keywords: *language of diplomacy, translation, interpretation*

Оршил

Хүй нэгдлийн үеэс омог аймгуудын хооронд үүссэн зөрчил тэмцлийг эхэн үедээ хүчээр шийддэг байснаа, дайтаж, хүмүүсийн амь насыг сүйтгэхгүйгээр асуудлаа ярьж зөвшилцөж шийдэхийн зөв зүйтэйг ойлгох болжээ. Энэ үеэс дипломат ажиллагааны анхны үндэс суурь тавигдаж эхэлсэн гэж үзэж болох юм. Манай эриний өмнөх 12-р зуунд Египет дипломат үйл, түүний дүрэм журмын тухай гэрээ байгуулж байсан, эртний Энэтхэгийн “Манугийн цааз хууль” хэмээх улс төр, эрх зүйн бичигт улсын элч ямар чадвар эзэмшсэн байвал зохих тухай дурдсан байдаг нь, эртний Хятадын түүхийн бичигт талууд маргаантай асуудлаа харилцан ярилцаж, бие биедээ үл довтолж тухай гэрээ байгуулж байсан гэх зэрэг олон баримт, археологийн олдворууд хүн төрөлхтний соёл иргэншлийн эхэн үеэс дипломат үйл ажиллагаа оршин тогтносоор ирснийг нотолдог (Н.Отгонбаяр, 2013:52-53). Дипломат (грек хэлний *diploma*-албан бичиг баримт)-хавтас гэсэн утгатай. 1693 онд Германы гүн ухаантан Лейбниц “*diplomatic*” гэдэг үгийг тэмдэг нэрийн үүргээр олон улсын харилцаанд холбогдох гэсэн утгаар анх ашигласнаас хойш энэ утгаараа хэрэглэгдэх болсон. Францын дипломат Франсуа де Калиер (1645-1717) тэрээр 1670-1676 оныг хүртэл эхлээд Лонгвилийн Гүнгийн албанд, дараа нь Турины Гүнгийн албанд дипломат алба хашиж байжээ. 1693 оноос хааны гадаад албанд ажиллах болсон юм (www.merriam-webster.com/dictionary). Даничуудтай гэрээ хэлэлцээр амжилттай явуулахад мэргэшсэн тэрээр 1697 онд Ризвикийн их хуралд чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Үүний дараа жил түүнийг Франц руу эгүүлэн дуудаж хааны гадаад бодлогын зөвлөхүүдийн ахлахаар томилжээ. Энэ үедээ тэрээр үе үеийн дипломат харилцааны

⁵⁶Ахлах багш, МУИС, ШУС, Хүмүүнлэгийн Ухааны Салбарын ГХТөв

⁵⁷Ахлах багш, МУИС, ШУС, Хүмүүнлэгийн Ухааны Салбарын ГХТөв

оюутнуудын гарын авлага болон мөнхөд дурсагдах “Хаант улсуудтай гэрээ хэлэлцээр явуулах урлаг” хэмээх алдарт номоо бичжээ. Хэмжээгээр бага боловч мэргэжлийн өндөр түвшинд бичигдсэн уг ном Францын дипломат ажиллагааны тогтолцоог тодорхойлох онолын бүтээл болсон байна. Мөн номд дипломат албандаа үнэнч шударгаар зүтгэж, жинхэнэ мэргэжилтэн болохыг онцлон зөвлөсөн байдаг. Тэрээр уг номдоо “дипломат” гэдэг үгийг одоо орчин цагт хэрэглэж байгаа утгаар анх ашигласан байна. Уг бүтээл хэвлэгдсэн үеэс хойш “дипломат” гэдэг үг нь онолын үндэстэй, ёс зүйн дээд зарчимд тулгуурласан салбар шинжлэх ухааны нэр хэмээн тооцогдох болжээ. Дипломат үйл ажиллагаа бол улс хоорондын харилцааны албан ёсны арга хэлбэр юм. Өөр өөр хэлтэй улсууд хоорондоо харилцахад нийтлэг ойлголцох хэл байхгүйн улмаас үл ойлголцол үүсэх эрсдэл байнга оршсоор байсан. Ийм нөхцөл байдал нь улсуудын харилцаанд нийтлэг нэг хэл байх шаардлага, эрэлт хэрэгцээг бий болгосоор байлаа. Хэдийгээр дипломат үг хэллэгийн тайлбар толинд энэ тухай дурдсан байдаг ч бодит байдал дээр өнөөг хүртэл тусгайлсан дипломат харилцааны хэл гэж байгаагүй. Иймээс бид англи, орос, монгол болон бусад хэлний тайлбар тольд тодорхойлсноор тухайн олон улсын гэрээ хэлэлцээрийг явуулж байгаа хэлийг эсхүл олон улсын харилцаанд ашиглах тухайн бичиг баримт, гэрээ хэлэлцээрийг үйлдсэн хэлийг дипломат харилцааны хэл гэж ойлгох хэрэгтэй.

Дипломат харилцаанд түгээмэл хэрэглэгдэж байсан хэл

Хэдийгээр дэлхий дахинд бүх улс хүлээн зөвшөөрч хоорондын харилцааны хэрэглүүр болгон ашиглаж байсан тусгай хэл байгаагүй ч тухайн түүхэн цаг үед улс төр, цэрэг дайн, нийгэм, эдийн засаг, соёл гэх мэт олон талаар хүчирхэг улсуудын хэлийг голчлон давамгайлж хэрэглэж байсан түүхтэй. Тухайлбал: эртний акади болон египет хэлээр үйлдэгдсэн МЭӨ 12-р зууны бичвэрийг эрдэмтэд нарийвчлан судалж үзээд уг бичвэрийн эхийг акади хэлээр бичиж египет хэлнээ хөрвүүлсэн байна гэж үзжээ. Мөн түүнээс хойшхи үед хамаарах бичвэрийн судалгааны үр дүнд акади хэл эртний дорнын улсуудын дипломат харилцааны гол хэл байжээ гэж үзсэн байна. Уг хэл дипломат харилцаанд мянга гаруй жил хэрэглэгдэж байгаад арамей хэлэнд байраа тавьж өгсөн байна. Арамей хэл 1500 гаруй жилийн турш энэ бүсэд улсууд хоорондоо харилцах харилцааны гол хэл нь байжээ. Их Александр буюу Македоны III Александр Грекийн хот улсуудын бослогыг дарж, Македоны нөлөөг улам хүчирхэгжүүлж, хойд хөршүүд рүүгээ, дараа нь зүүн зүгт Перс, цаашлаад, Анатоли, Сири, Египетийг байлдан дагуулж газар нутгаа зүүн зүгт Энэтхэг хүртэл тэлжээ. Александрын их ялалтын ачаар грек хэлний нөлөө нэмэгдэж, дипломат харилцаанд арамей хэлтэй хамт хэрэглэгдэх болсон гэдэг (Б. Батчимэг, 2019:4-5).

Грек хэлний халааг латин хэл үргэлжлүүлсэн байна. Лаций болон эртний Ромд уг хэлээр харилцаж байжээ. Ромын байлдан дагуулалтаар уг хэл Газар дундын тэнгис, Европ дахинд тархсан байна. 17-р зууныг хүртэл латин хэл Европ дахинд шинжлэх ухаан, дипломат харилцааны хэлний үүрэг гүйцэтгэж байлаа. Уг хэл ийнхүү хэдэн зууны турш дипломат харилцаанд үүрэг ач холбогдлоо алдахгүй явсаар ирсэн нь дараах хүчин зүйлүүдтэй холбоотой. Үүнд: тухайн цаг үед латин хэл шашны хэл байсан, дипломат албанд ажиллах хүмүүс ихэнхдээ

шашны санваартны гэр бүлээс гаралтай байдаг байв. Мөн уг хэл нь мөхсөн хэлэнд тооцогддог байсан учраас дипломат ажиллагаанд ашиглах нь аль нэгэн улсын нэр хүндэд халдахгүй, эрх тэгш харилцах боломжийг олгож байсан. Ийнхүү дипломат үйл ажиллагаанд олон зууны турш ашиглагдаж ирсэн учир орчин цагийн олон улсын харилцааны, эрх зүйн үгсийн санд латин гаралтай үг олон байдаг. Жишээ нь: **persona non grata**-тааламжгүй этгээд, **status quo**-нэгэнт буй болсон нөхцөл байдал, тогтсон журам; эд юмсын оршин байгаа байдал, **status quo ante** -урьд өмнө нь байсан байдал, **ad hoc**-тусгай, түр хугацаанд, тусгай зорилгоор, **de facto**-байгаа байдлаар нь, бодит байдал, **de jure** хууль ёсны гэх мэт (Ц.Цолмон, 2010). Сэргэн мандалтын үед баруун Европт латин хэл аажмаар ач холбогдлоо алдаж эхэлсэн. Улс төр, нийгэм, эдийн засаг, хуулийн салбарын олон нэр томъёо шинээр гарч ирлээ. Хэвлэх машин зохион бүтээсэн нь бичиг үсэг тайлагдах өргөн боломжийг нээж, шашны номлогчдын нөлөө буурч ирсэн. Өмнө нь зөвхөн латин хэлээр шашны номлогчдын латин хэлээр бичсэн зохиол бүтээлийг хязгаарлагдмал хүрээнд ашигладаг байсан бол энгийн хүмүүсийн ойлгох хэлээр нь ном зохиолууд хэвлэж эхэлсэн. Улмаар сүм хийдтэй ямар ч холбоогүй, латин хэл мэддэггүй дипломатуудын тоо олширсон.

1670-аад оны үед Франц хүчирхэгжиж нөлөө нь нэмэгдэж байгаад 14-р Луй хааны үеэс цэрэг, батлан хамгаалах, улс төрийн хувьд нөлөө нь буурчээ. Гэвч Европ дахины оюуны салбарт нөлөө нь тасралтгүй өсөж ирсэн нь франц хэл дипломат харилцааны гол хэл болоход түлхэц болсон. 1714 онд Франц Ариун Ром хоорондын дайнд Франц ялагдал хүлээж Растадын энхийн гэрээ байгуулав. Энэ гэрээний бичвэрийг латин хэлээр үйлдэх ёстой байсан ч Францын генерал Вилларс латин хэл мэддэггүй, Ромын армийн командлагч нь францаар сайн ярьж чаддаг байсан учир франц хэлээр үйлджээ. Ингээд уг гэрээнд франц хэлийг зөвхөн энэ тохиолдолд ашигласан, энэ нь цаашид байгуулагдах бусад гэрээнд уг хэлийг албан ёсны хэл болгон ашиглах үндэслэл болохгүй хэмээх тэмдэглэл хийсэн байна. Үүнээс хойш олон гэрээ, бичиг баримт франц хэлээр үйлдэгдэж байсан ч дээрх заалтыг бараг хагас зууны турш хавсаргажээ. Эцэст нь 1763 оны Парисын гэрээнд франц хэлтэй холбоотой заалт анх удаа хэрэглэгдээгүй. Энэ цагаас эхлэн франц хэл олон улсын гэрээ хэлэлцээрийн гол хэл болохыг дэлхий дахин хүлээн зөвшөөрөх болжээ. Наполеон Бонапартын уналтаас хойш Франц улсын улс төрийн нөлөө суларсан ч дипломат үйл ажиллагаанд франц хэлний давамгайлал хэвээр хадгалагдсаар байлаа. Харин бусад салбарт тус улстай өрсөлдөх шинэ улс гарч ирсэн нь АНУ байлаа. Их Британи Европын эх газраас тусгаарлагдмал байсан тэр цаг үед дипломат үйл ажиллагаанд англи хэл онцын нөлөөгүй байлаа. Удалгүй тус улсын Европ болон дэлхийн бусад оронд нөлөөгөө тэлэх бодлого идэвхэжсэнээр англи хэлний нөлөө аажмаар нэмэгдэв. Англи улсаас гадна АНУ 19 дүгээр зууны эхэн үеэс улс төрийн тавцанд хүчирхэгжих болсноор англи хэл дипломат үйл ажиллагаанд түрэн орж ирсэн. 1783 оны Парисын гэрээгээр АНУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн (Ю. Сандаг, 2011). Америкийн талын хүсэлтээр уг гэрээг англи хэлээр үйлджээ. 1895 онд Англи болон АНУ-ын хооронд Берингийн хоолойтой холбоотой асуудлаар үүссэн маргааныг шийдвэрлэх хурлыг Парис хотноо зохион байгуулсан. Талууд энэ

хурлыг англи хэлээр явуулахыг харилцан зөвшөөрсөн. Япон Оросын хооронд Портсмутын энхийн гэрээг Америкийн дипломатын зуучлалаар байгуулсан бөгөөд гэрээг англи, франц хэлээр үйлджээ. Дэлхийн нэгдүгээр дайн дууссан тухай энхийн гэрээ байгуулахад ялалт байгуулсан орнуудын удирдагчдын хэлний мэдлэгийн асуудал гарч иржээ. Жорж Клемансо болон Витторио Эмануэль Орландо нар англиар чөлөөтэй ярьдаг, харин Британийн Дэвид Лойд Жорж францаар бага зэрэг ярьдаг, Америкийн Вудро Вильсон франц хэл мэддэггүй байсан тул энхийн гэрээг англи, франц хэлээр үйлдсэн байна. 1714 оны Растадын энхийн гэрээнээс хойш баруун Европын дипломат ажиллагаанд франц хэлнээс гадна өөр хэл ашигласан анхны тохиолдол энэ байв. Мэдээж хэрэг энэ үйл явдлыг франц хэл хамгаалагчид хурцаар шүүмжилсэн. Хэдийгээр ийнхүү тэмцэж байсан ч хэрэг явдал нэгэнт өнгөрсөн нь тодорхой байлаа. Учир нь Версалийн гэрээгээр дипломат ажиллагаанд нөлөөлж байсан франц хэлний ноёрхолд цэг тавьжээ. Энэ үеэс олон улсын аливаа гэрээ хэлэлцээрийг англи, франц хэлээр үйлдэх болжээ. Эдгээр хэлийг ижил түвшинд дипломат яриа хэлэлцээрт хэрэглэх цаг үе дэлхийн хоёрдугаар дайнаар дуусгавар болж англи хэлийг дангаар хэрэглэх болсон. Хэдийгээр франц хэлний нөлөө ийнхүү буурсан ч дипломат үйл ажиллагаанд ашиглахаа огт больсон гэсэн үг биш. Франц хэл өнөөдөр НҮБ-ын албан ёсны хэлний нэг. Мөн Гаагийн Олон Улсын Шүүх, Европын Зөвлөл, Европын Аудитын Шүүх, Европын Холбооны Ерөнхий Шүүхийн албан ёсны хэл. Спортын дипломат ажиллагааны томоохон үйл явдал болох Олимпийн тоглолтын албан ёсны хэл нь франц хэл юм. Орчин цагийн олон улсын харилцааны үгсийн санд франц гаралтай олон үг хэллэг байдаг. Жишээ нь: **agrement зөвшөөрөл/агремен** (хүлээн авагч улс шинээр томилогдсон дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнийг зөвшөөрч буйн албан ёсны нотолгоо. Томилогдсон улс руу нь илгээхээс өмнө зөвшөөрөл заавал авах ёстой. Зарим тохиолдолд тухайн ажилтны өнгөрсөн намтар, үйл ажиллагаанаас шалтгаалан зөвшөөрөл өгөхөөс татгалздаг), **aide memoire санамж** (хэлэлцэж буй асуудал, гэрээ хэлэлцээрийн ерөнхий агуулгыг тусгасан бичиг. Хаяг, элчин сайдын яамны тамга, мэндчилгээний үг, гарын үсгийн аль нь ч шаардлагагүй. Дээд хэсэгт “Санамж” гэж гарчиглан бичээд харин доод хэсэгт он сар бичдэг. Тухайн дипломат төлөөлөгч томилогч улсынхаа засгийн газрын байр суурийг төлөөлөн илэрхийлэхдээ яригдаж буй асуудлын дарааллыг алдагдуулахгүй байх, хоёрдугаар зэргийн ач холбогдолтой зүйлд илүү ач холбогдол өгөхөөс зайлсхийх, засгийн газрын байр суурийг илэрхийлэхдээ ямар нэг зүйлийг орхигдуулахгүй байх зэрэгт тустай байдагт нь санамжийн гол ач холбогдол оршино), **attaché** атташе, **chargé d'affaires** (хэргийг хамаарагч), **chargé d'affaires ad interim** хэргийг түр хамаарагч (дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн түр эзгүй эсвэл шинээр томилогдсон тэргүүн ирэх хүртэл хугацаанд төлөөлөгчийн газрыг түр орлон тэргүүлдэг), **chargé d'affaires en titre** хэргийг хамаарагч (төлөөлөгчийн газрын хэргийг хамаарагч. Ийм төлөөлөгчийн газар нь элчин сайдын яам болон легацтай адил биш. Тиймээс ч тэргүүн нь зиндааны гуравдугаар ангилалд хамаарна. Аль нэг улсын гадаад хэргийн сайд нь нөгөө улсын гадаад хэргийн сайдад хэргийг хамаарагчаа итгэмжлэн томилдог), **communiqué** хамтарсан мэдэгдэл буюу коммунике (дээд хэмжээний уулзалт болон өндөр дээд хэмжээний айлчлал, олон улсын бага хурлуудын төгсгөлд үйлдэгддэг бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл

буюу баримт бичиг (<http://www.consul.mn/file/48%20Diplomat%20hariltsani%20convents.pdf>). Энэхүү баримт бичиг нь тунхаг бичгүүдтэй ерөнхийдөө тун төстэй гэхдээ ямар ямар асуудал хэлэлцэж, бодлогын ямар асуудлаар зөвшилцөлд хүрсэн талаар олон нийтэд тодорхой ойлголт өгдөг. Коммуниекг хамтарсан мэдэгдэлтэй адилтган тайлбарлаж болох ч олон улсын гэрээтэй адил түвшинд авч үзэж болохгүй, харин “хэвлэлд зориулсан мэдэгдэл “ хэмээн нэрлэж болно. Нэмж хэлэхэд, 1972 оны 2-р сард Коммунист засаглалтай Хятад улсад АНУ-ын ерөнхийлөгч Ричард Никсоны хийсэн түүхэн айлчлалын төгсгөлд “Шанхайн Коммуниек” баримт бичгийг үйлдэж баталсан нь энэ төрлийн баримт бичгүүд ямар чухал ач холбогдолтойг харуулсан явдал болсон), **demarche** демарш (дипломат төлөөлөгчийн зүгээс гаргаж буй санал, санаачлага, хийж буй алхам), **detente** намжмал байдал (хурцадмал нөхцөл байдал намжих) гэх мэт. Англи, франц хэлнээс гадна өнөө цагт дипломат ажиллагаанд бусад хэлээр харилцах болсон. Жишээ нь: Шанхайн Хамтын ажиллагааны Байгууллагын албан ёсны хэл нь хятад, орос хэл, ОПЕК буюу Газрын Тос Экспортлогч Орнуудын Байгууллагын албан ёсны хэл нь араб, англи, испани хэл байна. Эвсэлд үл нэгдэх орнуудын дээд хэмжээний уулзалтыг араб, анги, франц, испани хэлээр зохион байгуулдаг. Англи, франц хэлнээс гадна араб, хятад, орос, испани хэл НҮБ-ын албан ёсны хэл юм. Олон улсын байгууллагууд ийнхүү олон хэлээр харилцах болсноор орчуулга, хэлмэрчлэхүйг ч мөн олон хэлээр явуулах эрэлт хэрэгцээг бий болгов. Энэ цаг үеийг нэг хэлний ноёрхлын бус олон хэлний харилцааны үе гэж тодорхойлох болжээ. Олон улсын байгууллагуудад орчуулгын зардал ч багагүй нэмэгдэж байна. Хэдэн жилийн өмнө НҮБ-ын албан ёсны бүх хэлээр нэг хуудас албан материал орчуулах зардал нь Энэтхэгт нэг хүний бүтэн жилийн амьжиргааны өртөгтэй тэнцэж байгаа тухай тооцоо гарч байжээ. Хэдийгээр албан ёсны хэл нь адил ч тухайн орнуудын соёлын ялгаанаас үүдэн зарим үгийн утга, агуулга ялгаатай байх нь бий. Тухайлбал: Франц, Бельги, Канад, Швейцарь, Африкийн орнуудын төлөөлөгчид францаар хоорондоо чөлөөтэй харилцаж ойлголцовч тэдний соёл уламжлал нь өөр.

Дипломат харилцаанд хэлний мэдлэгтэй холбоотой асуудлыг

шийдвэрлэх тухай

Олон арга байдаг ч аль нь төгс биш юм. Олон улсын арга хэмжээ, яриа хэлэлцээр дээр дипломатууд аль хэлээр ярихаа сонгох эрхтэй. Ялангуяа яриа хэлэлцээр хийж буй талынхаа эх хэлийг сайн мэддэг бол тэр хэлээр нь ярих нь үр дүнтэй гэж үздэг. Заримдаа хэлний сонголт дипломат ажиллагааны нарийн тактик болох нь ч бий. Тийм ч сайн ярьдаггүй хэлээрээ ярих шаардлага ч үүснэ. Эелдэг боловсон ёсны үүднээс тухайн улсын нь хэлээр нь ярих зөв тактик болох нь ч бий. Төрийн тэргүүнүүд, өндөр дээд албан тушаалтан, дипломат төлөөлөгчид бусад улс оронд айлчлахдаа, зарим олон улсын хурал, чуулганд оролцохдоо тухайн үйл ажиллагааг зохион байгуулж байгаа орны хэлээр мэндлэх, үг хэлэх харилцах нь ихэнхдээ эерэг, нөхөрсөг уур амьсгал бүрдүүлдэг. Хэлний мэдлэгийн бэрхшээлээс зайлсхийх өөр нэг арга нь хэлэлцээрт оролцогч талуудын аль нэгний эх хэлээр яриа хэлэлцээрийг явуулах юм. Мөн яриа хэлэлцээрт оролцогч

талуудын аль алиных нь эх хэл биш, гуравдагч орны хэлийг сонгож болно. Энэ нь оролцогч талуудын аль нэг нь хэлний мэдлэгийн давуу байдлаа шударга бусаар ашиглахаас сэргийлэх боломж олгоно. Энэ аргыг олон улсын дипломат ажиллагааны практикт энгийн хүлээн авалтууд багахан уулзалтуудад түгээмэл ашигладаг. Олон хэлний бэрхшээлээс үүдэн зохиомол хэлийг, тухайлбал эсперанто хэлийг ашиглах хандлага гарч байлаа. Гэвч энэ нь төдийлөн нийтийн дэмжлэг аваагүй юм. Олон улсын гэрээ хэлэлцээр, хурал чуулга, айлчлал, хүлээн авалтад оролцогчдын хэл, үндэс угсаа өөр өөр нөхцөлд орчуулагч, хэлмэрчээр дамжуулан харилцах нь хамгийн түгээмэл. Дипломат ёслолын горим журмын дагуу, төрийн тэргүүн, дээд хэмжээний төлөөлөгч нь зарим албан ёсны арга хэмжээн дээр өөрийн эх хэлээр ярихыг зөв тактик гэж үздэг.

Дипломат харилцаанд орчуулагч хэлмэрчийн гүйцэтгэх үүрэг

Версалийн гэрээнээс хойш олон улсын харилцаанд, яриа хэлэлцээрт албан ёсны хоёр хэлийг ашиглах болсонтой холбоотойгоор энэ салбарын мэргэжлийн орчуулагч хэлмэрчийн эрэлт хэрэгцээ бий болов. Хэдийгээр цоо шинэ үзэгдэл биш байсан хэдий ч дипломат харилцааны орчуулагч, хэлмэрчийг албан ёсоор тусгайлан бэлтгэх мэргэжлийн боловсролын суурь тавигдаж эхэлсэн. Эрт цаг үед омог аймгуудын хооронд харилцан ойлголцоходоо дайтагч талаас өөрийн талд урвуулж авсан хүнийг сургаж тэднээр хэлмэрчлүүлдэг байсан аж. Гэхдээ түүхэнд хэлмэрчид төдийлөн үнэнч байдаггүй, урвах нь элбэг байсан тул аль нэг талд хамааралгүй хүмүүсээр хэлмэрчлүүлдэг байжээ. Олон талт яриа хэлэлцээрт хэлмэрчлэх нь хоёр талын яриа хэлэлцээрт хэлмэрчлэхээс үндсээрээ ялгаатай. Олон талт яриа хэлэлцээрийн хэлмэрч нь оролцогчийн ярьж байгаа сэдвийг, илтгэлийн агуулгыг сайн мэддэг байхад л хангалттай бол хоёр талын яриа хэлэлцээрт хэлмэрчлэх үед хэлмэрчийн ярьж байгаагаас гадна түүний дохио зангаа, биеийн, сэтгэлийн хөдөлгөөний илэрхийллийг хоёр тал их анхааралтай ажигладаг, энэ нь цаашлаад талуудын гаргах шийдвэрт нөлөөлдөг учир орчуулагч хэлмэрчээс ихээхэн хариуцлага шаарддаг байна. Олон улсын яриа хэлэлцээрийг орчуулагч, хэлмэрчээр дамжуулан явуулах нь зарим талаар сөрөг үр дагавартай байх нь ч бий. Цаг их зарцуулахаас гадна хамгийн ноцтой нь орчуулгын алдаа гарах магадлал юм. Орчуулагчийн хэлний мэдлэгээс гадна, бусад олон хүчин зүйлээс шалтгаалан алдаа хэзээ ч гарч болно. Санаатай болон санаандгүй гаргасан алдаа дипломат ажиллагаанд ихээхэн хохирол учруулдаг. Тийм ч учраас дундад зуунд Италид орчуулагч урвагч хоёрыг зоосны хоёр тал гэж егөөдөн нэрлэдэг байжээ. Гадаад хэл сурсан хэн ч орчуулгыг толь бичиг ашиглаад юм уу эсхүл хэлний мэдлэгтээ тулгуурлаад хийчихдэг амар хялбар зүйл мэтээр ташаа ойлгодог. Гэтэл үнэн хэрэгтээ орчуулга бол уйгагүй хөдөлмөрлөж, шамдан суралцаж байж эзэмшдэг чадвар юм.

Орчуулагч Натали Келли, Жос Зецшэ нар орчуулгын ертөнцөд сонирхогч орчуулагчийн багахан хэмжээний бичвэрээс эхлээд олон улсын томоохон арга хэмжээ, тухайлбал Олимп, хөл бөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээний орчуулгад судалгаа хийж цуглуулсан материалаа эмхэтгэн “Found in Translation” номоо хэвлүүлжээ. Уг номд орчуулгын ялыгүй мэт санагдах алдаа ямар ноцтой үр дагаварт хүргэсэн тухай олон жишээнээс энд заримыг дурдъя. 1977 онд Америкийн

ерөнхийлөгч Картер Польш улсад айлчлах үеэр түүний хэлмэрчээр польш хэлний мэдлэгтэй орос орчуулагчийг дагалдуулан явуулжээ. Харамсалтай нь тухайн орчуулагч нь олон улсын харилцааны мэргэжлийн орчуулга, хэлмэрчлэхүйн туршлагагүй байжээ. Тэрээр Картерийн хэлсэн үгийг дараах байдлаар орчуулж хоёр орны хэвлэлийнхний шүүмжлэлийн бай, элэг доог болжээ. Картер “би АНУ-с танай улсыг зорин мордохдоо (эсхүл гарахдаа)” гэж хэлснийг нь польшоор “би Америкийг хаяад гарахдаа” гэж ойлгогдохоор, “ирээдүйнхээ төлөөх та бүхний хүсэл тэмүүлэл, эрмэлзлэл” гэснийг “ирээдүйнхээ төлөөх та бүхний шунал” гэж ойлгогдохоор орчуулсан байна. Өөр нэг жишээ сэргөлдөгч талуудын хооронд бараг дайн гаргахад хүргэсэн байна. Үүнд: Хүйтэн дайны оргил үед Зөвлөлтийн тэргүүн Никита Хрущёвын хэлсэн үгийг буруу орчуулснаас “бид та нарыг булшилна, оршуулна” гэсэн утгатай болж энэ нь АНУ-ын эсрэг цөмийн халдлага хийж булшлах гэж байгаа мэт ойлголтыг төрүүлэн, ЗХУ, АНУ-ын зөрчлийг хурцатгахад хүргэж байжээ. Үнэн хэрэгтээ энэ нь “Та нарын үе дууссан ч бид амьдарсаар байх болно” гэсэн утгатай байжээ. Энэ нь хэдийгээр найрсаг үг биш ч бас заналхийлэл байгаагүй юм. Тухайн үеийн нөхцөл байдал, өөр бусад шалтгаан байсан ч, аймшигтай, гамшигт үр дагавар авчрах шалтаг болсон орчуулгын алдааны жишээ: АНУ-ын Засгийн газар Подстамын тунхаглал гаргаж Японыг бууж өгөхийг шаардсан. Үүний хариуд Японы ерөнхий сайдын хэлсэн үгэнд “мокусацу” гэдэг үг орсон байсныг буруу орчуулж “бид энэ шаардлагыг хэрэгсэхгүй, байна” гэсэн утгаар орчуулсан нь хэдхэн өдрийн дараа Хирошимад атомын бөмбөг хаяж олон мянган хүн амийг авч одох эмгэнэлтэй үр дагаварт хүргэжээ. Үнэн хэрэгтээ дээрх үг нь “Одоохондоо бид тайлбар өгөх боломжгүй байна. Бид бодож байна. асуудлыг ярилцаж байна” гэсэн утгатай байсан ажээ.

Орчуулагч, хэлмэрчийн мэргэжлийн бэлтгэл

Орчуулах, хэлмэрчлэх үйлийн гол зорилго бол нэг хэлээр боловсруулсан мэдээллийг нөгөө хэлэнд тухайн хэлний нэгжийг ашиглан буулгах явдал юм. Орчуулагч хэлмэрч нь хэлний төгс мэдлэгээс гадна, нийгмийн түгээмэл салбарын өргөн мэдлэгтэй байх ёстой. Нэг ойлголтыг янз бүрийн өнцгөөс харж өөр өөрөөр тайлбарладаг нь соёлын олон ялгаа үүсэх үндэс болдог. Орчуулагч хэлмэрч энэ ялгааг ойлгож харилцагч талуудын хооронд нэгдмэл ойлголт бий болгоход хувь нэмрээ оруулах үүрэгтэй. Хятадын дарга Мао Зедун Америкийн Төрийн нарийн бичгийн дарга Хенри Киссенжерийг борооны өмнөх хараацай шувуутай зүйрлэсний цаад утгыг хэлмэрч нь ойлгож орчуулж чадахгүй дахин дахин тайлбарлуулсан гэдэг. Үүний утга нь хараацай шувуу нисэж ирвэл ямар нэг үйл явдал болохыг зөгнөдөг гэдэгтэй Хенри Киссенжерийн уг айлчлалыг зүйрлэж, энэ нь олон улсын улс төр, геополитикийн нөлөө, болзошгүй зөрчил тэмцэл, түүнээс үүсэх асуудлууд, тухайн уулзалтаар хэлэлцэх зэвсэг хураах, эдийн засгийн асуудал нь цаашдаа өргөн хүрээг хамрахын дохио болж байгаа тухай байжээ. Зарим тохиолдолд хэлмэрч нь илтгэгч, яриаг нь орчуулж байгаа хүндээ өгүүлж буй санаагаа зөв илэрхийлэхэд нь тусалдаг. Жишээ нь: олон улсын уулзалт, хурал арга хэмжээн дээр хүмүүсийн нэр, албан тушаал, заримдаа улс орныг нь андуурч хэлэх тохиолдол гардаг. Мэргэжлийн чадварлаг орчуулагч, хэлмэрч нь эх болон гадаад хэлний төгс мэдлэгтэй байхаас

гадна тухайн салбарын талаар өргөн мэдлэгтэй байх ёстой. Хэлмэрч орчуулагч олны өмнө гараад сандарч мэгддэггүй байх ёстой. Хэлмэрчлүүлж байгаа хүний нэр нөлөө, албан тушаал өндөр дээд байхын хэрээр түүний хэлмэрч “тайзны айдас”-саа төдий хэрээр ангижирсан байх хэрэгтэй. Орчуулагч, хэлмэрчид тавигдах бусад шаардлагад мэдээллийн нууцыг хадгалж чаддаг, логик сэтгэлгээ сайтай, яриа хэлэлцээрийн үеийн уур амьсгалын сайн мэдэрдэг түүнд дүгнэлт хийх чадвартай байх зэрэг юм. Хэлмэрч анхаарлаа удаан төвлөрүүлж чаддаг байх ёстой. Энэ бол хамгийн гол чадварын нэг юм. Хэлмэрчийн эзэмшсэн байвал зохих нэг мэдлэг бол “биеийн хэл” юм. Нэг улсад энгийн тооцогддог гар хөлийн хөдөлгөөн, дохио зангаа өөр нэг улсад ёс бус, бүдүүлэг эсхүл доромж утгыг илэрхийлэх нь бий учраас энэ талаар зохих мэдлэгтэй байх хэрэгтэй.

Хэлмэрчлэхүйн үеийн бэрхшээл

Хэлмэрчлэхүйд олон хүчин зүйлээс үүдэлтэй бэрхшээл тулгардаг. Илтгэгч нь ур чадвар муутай, илтгэлдээ сайн бэлдээгүй, өөрийгөө илэрхийлэхдээ муу байх эсхүл нэг өгүүлбэрт олон үгүйсгэл давхар хэрэглэх, яг тухайн агшинд өмнө нь хэрэглэж байгаагүй нэр томъёо зохион хэрэглэх нь хэлмэрч орчуулагчид ихээхэн бэрхшээл үүсгэдэг. Зарим илтгэгчийн аялга ялангуяа Энэтхэг, Пакистан, Арабын орнуудын төлөөлөгчид англиар ярьж байгаа үед орчуулахад ихээхэн төвөгтэй байдаг. Заримдаа өгүүлэгчийн гаргасан илэрхий алдааг хэлмэрч өөрөөс нь асуулгүйгээр засаж залруулах хэрэг гардаг. Жишээ нь: Өмнөд Солонгосын ерөнхийлөгчийг Умард Солонгосын ерөнхийлөгч гэж танилцуулахад хэлмэрч нь засаж орчуулж байжээ. Дипломат харилцааны түүхэнд улс орнуудын харилцаанд сэв суулгахгүй, найрсаг байдлыг хадгалах үүднээс орчуулгыг зориудаар өөрчилж байсан тохиолдол ч байдаг. Туркийн эзэнт гүрний султанаас Английн хатан хаанд илгээсэн захидалд орчуулагч зарим нэг өөрчлөлт хийсэн гэдэг. Учир нь Туркийн султан Английн хатан хааныг өөрийн зэрэг зиндааны хүн гэж үздэггүй байсан учир түүнд зэрэг дэв доогуур хүмүүст ханддаг байдлаар бичсэн байсныг нь орчуулагч өөрчлөн хатан хааны зэрэг дэвд зохих хүндлэлтэй үгээр сольсон гэдэг. Хэлмэрчдийн хувьд илтгэгч нь илтгэлээ ярих бус унших нь жинхэнэ хар дарсан зүүд лугаа явдал юм. Ийм нөхцөлд хэлмэрч тухайн илтгэлийг зохих ёсоор бүрэн дүүрэн хөрвүүлэх боломжгүй болдог. Орчуулагч, хэлмэрчид энгийн нөхцөлөөс гадна дайн, байгалийн гамшиг, онц байдлын үед ажиллах шаардлага гардаг. Ийм үед тэдэнд нь нэг талаас сэтгэл зүйн, нөгөө талаас ажлын ачаалал, болзошгүй алдаа, түүнээс гарах үр дагавраас үүдэлтэй айдас түгшүүр гэх мэт олон сорилт бэрхшээл тулгардаг. Ялангуяа дайны байдалтай байгаа газар орчуулагч, хэлмэрчээр ажиллаж байгаа хүмүүс сэтгэл зүйн хүнд дарамт, амь насаа ч алдаж мэдэх эрсдэлтэй байнга нүүр тулж байдаг. Тулааны талбарт бус, энэ чиглэлээр орчуулагч, хэлмэрчээр ажиллаж байсан хүмүүс ч ийм эрсдэлд орсон жишээ ч олон бий. Жишээлбэл: Америкийн цэргийнхэнд хэлмэрчилж байсан Афганийн иргэн Сахидадыг цэргийн орчуулагчаар ажиллах АНУ-ын тусгай визээ хүлээж байхад нь дайсагнагч талынхан барьцаалан амь насыг нь хөнөөжээ. Сүүлийн жилүүдэд мэдээллийн технологийн үсрэнгүй хөгжлийн ачаар орчуулагч хэлмэрч нар янз бүрийн техник, тоног төхөөрөмж, программ хангамж ихээр ашиглах болсноор тэдний ажлын бүтээмж, чанар сайжирч байна. Энэ нь нэг талаар дэвшилттэй, цаг

хугацаа, зардал хэмнэсэн, хүний хөдөлмөрийг хөнгөвчилсөн үйл ажиллагаа боловч, амьд харилцаанд суурилдаг ажил мэргэжлийн онцлогийг зарим талаар алдагдуулах эрсдэлтэй.

Олон улсын харилцаанд шинээр хэрэглэгдэж байгаа үг хэллэг тэдгээрийн орчуулга

Олон улсын харилцааны салбарт шинэ үг хэллэг ихээр нэмэгдэж байна. Тухайлбал: 2019 оны сүүлээр олон улсын харилцааны мэргэжлийн сэтгүүл, хэвлэл мэдээллээр “**thumb-boat diplomacy**” гэдэг үг гарч ирэв. Үүний цаад утгыг авч үзвэл АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп цахим сүлжээ, ялангуяа Твиттер ашиглан АНУ-ын дотоод, гадаад бодлого, олон улсын харилцаатай асуудлаар өөрийн байр сууриа илэрхийлсэн мэдээлэл байнга нийтэлдэг байдлыг нь **gunboat diplomacy** буюу зэвсгийн хүчээр далайлгах, айлгах сүрдүүлэх гэдэгтэй ойролцоо утгаар, гэхдээ энд зэвсэг бус цахим сүлжээг хүмүүс таалагдсан зүйлдээ эрхий хурууны дүрстэй зураг дардгаар төлөөлүүлсэн байна. Ингээд утгачлаад орчуулбал цахим сүлжээ ашиглан хүчээр далайлгах ажиллагаа гэсэн утгатай болж байна. Харилцаанд цахим сүлжээ өргөн ашиглаж байгаа байдлыг **virtual diplomacy**, **digital diplomacy** гэдгийг цахим дипломат ажиллагаа гэж ерөнхийлөн нэрлэдэг байсан бол одоо сүүлийн үед **Facebook diplomacy** фэйсбук дипломат ажиллагаа, **Twitter diplomacy** твиттер дипломат ажиллагаа гэх мэтээр нийгмийн сүлжээ тус бүрийн нэрээр нь нэрлэх болсон байна. Өмнө нь хэрэглэгдэж байсан утга нь өөрчлөгдсөн, эсхүл орчуулгыг эргэж харвал зохих үг хэллэгүүд ч олон байна. Тухайлбал:

global citizen: дэлхийн иргэн,

international community: олон улсын хамтын нийгэмлэг,

smart power: ухаалаг хүч,

right to self-determination: өөртөө засан тогтнох эрх,

superpower: хэт их гүрэн,

G20: Их 20-н бүлэг гэх мэт.

Үүнээс хоёр үгийн орчуулгыг авч үзье. **Superpower**: хэт их гүрэн. Хүйтэн дайны үед АНУ ба ЗХУ-г ингэж нэрлэж байсан. Харин нөхцөл байдал өөрчлөгдсөн өнөө үед их гүрэн, хэт их гүрэн гэх мэтийн энэ ангилал нэр томъёоноос татгалзвал зохино гэж олон улсын харилцааны мэргэжилтнүүд эрдэмтэд үзэж байна. **G20**: 20-н бүлэг. Энэ товчлолд “их” гэдгийг илэрхийлэх үг ороогүй. “G” нь бүлэг гэдэг англи үгний эхний үсэг юм. Үүнийг Их 20-н бүлэг гэж орчуулаад байгаа нь буруу юм. Иймээс олон улсын харилцааны мэргэжлийн үг хэллэгийн тайлбар толь бичгийг шинээр гаргах, дээр дурдсан болон бусад олон үг, нэр томъёоны орчуулгыг залруулах шаардлага тулгараад байна.

Дүгнэлт

Улс хоорондын харилцааны албан ёсны арга хэлбэр болох дипломат үйл ажиллагааны түүхэн хөгжлийн явцад аль нэг улсын хэл түгээмэл хэрэглэгдэж байсан нь ихэнхдээ тухайн улсын бүс нутаг дахь нөлөө, улс төр, эдийн засаг, соёлын хөгжил зэргээс шалтгаалж байжээ. Олон улсын яриа, гэрээ хэлэлцээрийг

хөтлөн явуулахад оролцогч талуудын харилцан ойлголцлыг хангахад нийтлэг хэлний үүрэг онцгой байдаг аж. Түүнчлэн улс орнууд, талуудын харилцан ойлголцлыг бэхжүүлэхэд орчуулагч хэлмэрчийн гүйцэтгэх үүрэг чухал байдаг байна. Олон улсын байгууллагуудад албан ёсны хэл зөвхөн англи франц зэрэг цөөн хэлээр хязгаарлагдахаа больж бусад хэлээр харилцах нь улам бүр нэмэгдсэн байна. Мөн техник технологийн дэвшлээ дагаад харилцааны шинэ хэлбэрүүд бий болж байгаагийн тод жишээ нь цахим харилцаа юм. Цахим харилцааны хэрэглээ улам бүр өргөжиж фэйсбук, твиттер дипломат ажиллагаа гэх мэт шинэ хэлбэрүүд гарч ирэв. Олон улсын харилцааны салбарт шинэ үг хэллэг ихээр нэмэгдэж байна. Өмнө нь хэрэглэгдэж байсан утга нь өөрчлөгдсөн, тухайн ойлголт нэгэнт дуусгавар болсон утгыг илэрхийлсэн үг хэллэгүүд ч олон байна. Үүнийг эргэн харж засаж залруулах шаардлагатай.

Номзүй

Монгол хэлээр:

1. Аким Г. (1984), Орчуулгын санг уудлахад. УБ.
2. Алтангэрэл Д. (2002), Монгол Англи толь. УБ.
3. Алтангэрэл Д. (2002), Англи Монгол толь. УБ.
4. Батчимэг Б. (2019), Олон улсын харилцааны мэргэжлийн үг хэллэгийн тайлбар толь бичиг. УБ.
5. Гүрбазар Р. (1996), Орчуулгын онол дадлагын асуудал. УБ.
6. Дипломат баримт бичиг боловсруулалт, орчуулга (2014), Орчуулах эрдэм-10 хурлын эмхэтгэл. УБ.
7. Отгонбаяр Н. (2013), Дэлхийн улс төр, эрх зүйн сэтгэлгээний дээж бичиг-1, УБ. БТМ хэвлэх үйлдвэр.
8. Цолмон Ц. (2010), Дипломат ёс горим, ёслол, баримт бичиг. УБ.
9. Цэвэл Я. (1966), Монгол хэлний товч тайлбар толь. УБ.
10. Сандаг Ю. (2011), Дипломат баримт бичиг тэдгээрийн түгээмэл хэлбэр. УБ.

Гадаад хэлээр:

1. Bawden C. (1997), English Dictionary. London & New York.
2. Muratov E. N. (2005), Diplomatic Documents and Diplomatic Correspondence in English. Moscow

Цахим эх сурвалж:

1. Merriam-Webster.com Dictionary, Merriam-Webster, <https://www.merriam-webster.com/dictionary/diplomatic>. Accessed 20 March. 2020.)
2. Дипломат Харилцааны Тухай Венийн Конвенц, <http://www.consul.mn/file/48%20Diplomat%20hariltsani%20convents.pdf>
3. <https://thediplomat.com/topics/diplomacy/>
4. <https://en.wikipedia.org/wiki/Diplomacy>
5. <https://www.britannica.com/topic/diplomacy>